

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ НЭГТГЭСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:

ДУА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Аудитын менежер Х.Наранцацрал

Аудитор Б.Гантуяа

Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Утас: 7059-3113

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 07/05

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан”-д хийсэн аудитын тайлан /ДУА-2022/01/НА-СТА-ТЕЗ/-г нэг дүгээр хавсралтаар баталсугай.

2. “Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан”-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад д тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/-д зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2022 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор /Т.Батсайхан/, аудитор /Т.Оюун-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ



00100101/5



Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөөг бууруулан баталсан байна.	6-8
Аудитор: Б.Гантуяа Т.Оюун-Эрдэнэ	1.2 Орон нутгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.	9-11
	2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА	
	2.1 Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ хэмнэлтийн горим зөрчин урсгал зардлыг 5.0 хувиар нэмэгдүүлсэн байна.	12-17
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7059-3113 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.2 Төсвийн зарцуулалттай холбоотой нийт зөрчлийн 13.2 хувь нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтийн горим зөрчин зарцуулсан зөрчил байна.	18-21
	2.3 Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.	22-23
ХАЯГ:	Дүгнэлт	24
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 210 тоот	Зөвлөмж	25
2022 оны 4 дүгээр сар	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, аудитын газрын тайлбар	26-27
	Хавсралт	28-39



ТОВЧИЛСОН ҮГС

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШБ	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалган, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай зарцуулсан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн зохицуулалт хийсэн судалгаа, мэдээлэл болон татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль;
- Татварын багц хуулиуд;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Төрийн аудитын стандарт /MNS 6817-4:2020/, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Гантуяа, Т.Оюун-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

**1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО****1.1 Зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөөг бууруулан баталсан байна.**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг баталжээ.

Тус хуулийн 15 дугаар зүйлд Дундговь аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 10,942.1 сая, 17 дугаар зүйлд ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 6,694.7 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 28,214.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Өмнөх онтой харьцуулахад санхүүгийн дэмжлэг 729.4 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 408.7 сая төгрөгөөр тус тус буурч ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1,518.1 сая төгрөгөөр өссөн байна.

Дундговь аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх¹ хэсэгт заасны дагуу аймгийн ИТХ-д төсвийн төслийг өргөн мэдүүлж, төсвийн орлого, зарлагыг батлуулжээ.

Дундговь аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор 2021 оны орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 52,569.4 сая төгрөгөөр баталсныг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 55,638.6 сая төгрөг болгон 3,069.2 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Хүснэгт №1 /сая төгрөгөөр/

Эх үүсвэр		2020 оны төлөвлөгөө	2021 он		
		1	төлөвлөгөө 2	тодотгосон 3	зөрүү 4=3-2
Улсын төсвөөс	ТЗШ	28,623.3	27,482.4	28,214.9	732.5
	ОНХС	5,176.6	6,535.6	6,694.7	159.1
	ЭМД-ын сангаас	305.7	409.2	409.2	0.0
	Санхүүгийн дэмжлэг	11,671.5	10,412.8	10,942.1	529.3
Орон нутгийн төсвөөс	Татварын орлого	4,054.0	4,627.8	4,844.7	216.9
	Татварын бус орлого	420.8	361.1	761.1	400.0
	ОНЕО-ын үлдэгдэл	428.8	160.0	1,221.6	1,061.6
	Төвлөрүүлэх орлого	89.8	307.3	216.7	-90.6
	Урьд оны үлдэгдэл	1,115.6	2,273.2	2,333.6	60.4
дүн		51,886.1	52,569.4	55,638.6	3,069.2

Үүнээс татварын бус орлогыг 2.1 дахин, орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлийг 7.6 дахин нэмэгдүүлсэн нь материаллаг байна.

¹ Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 /Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ/



Тус тогтоолоор ХХОАТ-ын буцаан олголтыг гүйцэтгэлээр буюу 216.9 сая төгрөгөөр бууруулан баталжээ. Буцаан олголт буурсан нь иргэдийн орон сууц худалдан авалт буурсантай холбоотой байна.

Орон нутгийн орлогын талаар:

- Татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оноос нийт 270.7 сая төгрөгөөр нэмж баталсан боловч орлогын нэр төрлөөр авч үзэхэд зарим орлогуудыг хасаж баталсан байна.

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/

№	Татварын бус орлогын төрөл	2020 оны		2021 оны	Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	4=3-1	5=3-2
	А	1	2	3		
1	Хадгаламжийн хүүгийн орлого	751.9	777.3	629.9	-122.0	-147.4
2	Торгуулийн орлого	451.6	550.1	444.0	-7.6	-106.1
3	Бусад орлого	49.9	113.9	450.2	400.3	336.3
	Дүн	1,253.4	1,441.3	1,524.1	270.7	82.8

Үүнээс үзэхэд өмнөх оны орлогын төлөвлөгөө төрөл бүрээр давж биелсэн байхад тайлант оны торгуулийн орлого, хадгаламжийн хүүгийн орлогыг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлээс тус тус бууруулан баталсан байна.

- Харин татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөнөөс 1,641.2 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Хүснэгт №3 /сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2020 оны		2021 оны	Зөрүү	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	4=3-1	5=3-2
	А	1	2	3		
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах	3,545.0	3,958.8	4,200.0	655.0	241.2
2	Үйл ажиллагааны орлого	368.3	621.5	497.3	129.0	-124.2
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	87.0	126.5	170.0	83.0	43.5
4	Бууны албан татвар	15.9	18.3	19.5	3.6	1.2
5	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	267.9	299.1	300.0	32.1	0.9
6	Улсын тэмдэгтийн хураамж	145.0	152.0	185.0	40.0	33.0
7	Газрын төлбөр	218.8	351.7	286.1	67.3	-65.6
8	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	200.0	246.2	50.0	-150.0	-196.2
9	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	30.4	182.8	167.3	136.9	-15.5
10	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	25.0	100.7	60.0	35.0	-40.7
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	19.2	20.5	28.5	9.3	8.0
12	Бусад татвар, хураамж	36.1	42.9	56.9	20.8	14.0
13	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	134.7	146.1	149.6	14.9	3.5
14	ХХОАТ-ын буцаалт	-312.3	-312.3	-283.1	29.2	29.2
15	малд ноогдох албан татвар			600.4	600.4	600.4
17	Хөрөнгө борлуулсны орлого	129.5	142.7	64.2	-65.3	-78.5
	Дүн	4,910.5	6,097.5	6,551.7	1,641.2	454.2

Өмнөх оны татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзвэл дуудлага худалдаа

сонгон шалгаруулалтын орлого, хөрөнгө борлуулсны орлого тус бүр давж биелсэн байхад тайлант оны орлогыг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлээс бууруулан баталсан байна.

Татварын болон татварын бус орлогын сүүлийн таван жилийн төлөвлөгөөг орлогын нэр төрөл тус бүрээр харьцуулан үзэхэд төлөвлөгөөг жил бүр нэмж баталсан дараах 2 орлого байна.



Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөөг 85.8-11.1 хувиар жил бүр нэмэн төлөвлөж, орлогын төлөвлөгөө жил бүр тасарч байсан бол сүүлийн 2 жил 8.1-16.5 хувиар давж биелсэн байна. Энэ нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлж хэвшиж байгаатай холбоотой байна.



Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг жил бүр 13.0-38.0 хувиар нэмж баталсан, гүйцэтгэлээр эхний 2 жил 8.7-32.4 хувиар давж биелж байсан бол сүүлийн 3 жил 2.1-4.6 хувиар тасарсан байна. Үүнээс үзэхэд төлөвлөгөө давж биелж байсан орлого төлөвлөлтөөс шалтгаалж тасарсан байна.

Тэгвэл орлогын төлөвлөгөө жил бүр харилцан адилгүй хэлбэлзэлтэй батлагдсан дараах орлогууд байна.



Эдгээр орлогыг урьдчилан тооцох боломжгүйгээс төлөвлөгөөг жил бүр гүйцэтгэлээр тодотгон баталдаг нь төлөвлөгөө хэлбэлзэх шалтгаан болж байна.

**1.2 Орон нутгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.**

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон аймаг, сумдын ИТХ-ын тогтоолын дагуу орон нутгийн төсвийн орлогыг дараах байдлаар баталж, бүрдүүлсэн байна.

Хүснэгт №4 /сая төгрөг/

Орлогын эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Аймаг			
ТЗШБ	28,214.6	28,068.7	(145.9)
Санхүүгийн дэмжлэг	10,942.1	10,942.1	-
ОНХС	6,694.7	6,689.5	(5.2)
Эрүүл мэндийн даатгал	409.2	215.2	(194.0)
Татварын орлого	5,605.8	6,193.3	587.5
Урьд оны үлдэгдэл	2,281.3	2,357.4	76.1
ОНЕО үлдэгдлээс	1,221.6	1,276.4	54.8
Төвлөрүүлэх орлого	268.9	380.9	112.0
Дүн	55,638.2	56,481.2	485.3.0
Сум			
Татварын орлого	2,505.0	3,558.9	1,053.9
Урьд оны үлдэгдэл	3,262.7	3,481.9	219.2
ОНЕО үлдэгдлээс	959.6	1,015.7	56.1
Төвлөрүүлэх орлого	1,899.7	2,319.5	419.8
Дүн	8,627.0	10,376.0	1,749.0
Нийт дүн	64,265.2	66,499.5	2,234.3

Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 100 хувь, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн 99.9 хувийг авчээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 28,124.6 сая төгрөгийг бүрэн авч гүйцэтгэлээр 28,068.7 сая төгрөгийг зарцуулан, 145.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалаас 409.2 сая төгрөгийн санхүүжилт авахаас эрүүл мэндийн төвүүдийн эмчилгээ, үйлчилгээний гүйцэтгэлээр 215.2 сая төгрөг буюу 52.6 хувийн санхүүжилтийг хүлээн авч тайлагнасан.

Төсөвт байгууллагын орлого 2,168.6 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 1,769.0 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 931.4 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 23.4-26.8 хувиар тус тус давуулан биелүүлжээ.

**Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Тайлант хугацаанд 6,551.7 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,793.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 119.0 хувь буюу 1,242.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5 /сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
				Зөрүү	Хувь
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах	4,200.0	4,466.4	266.4	106.3
2	Үйл ажиллагааны орлого	497.3	419.3	-78.0	84.3
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	170.0	166.5	-3.5	98.0
4	Бууны албан татвар	19.5	18.9	-0.6	97.1
5	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	300.0	303.6	3.6	101.2
6	Улсын тэмдэгтийн хураамж	185.0	138.1	-46.9	74.7
7	Газрын төлбөр	286.1	402.2	116.1	140.6
8	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	50.0	203.0	153.0	406.0
9	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	167.3	644.2	476.9	385.0
10	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	60.0	252.4	192.4	420.7
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	28.5	7.4	-21.1	26.0
12	Бусад татвар, хураамж	56.9	50.5	-6.4	88.8
13	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	149.6	174.3	24.7	116.5
14	ХХОАТ-ын буцаалт	-283.1	-283.1	0.0	100.0
15	Малд ноогдох албан татвар	600.4	695.0	94.7	115.8
17	Хөрөнгө борлуулсны орлого	64.2	135.0	70.8	210.2
	Дүн	6,551.7	7,793.8	1,242.1	119.0

Татварын орлогын төлөвлөгөө нийт 1,242.9 сая төгрөгөөр давж биелснээс материаллаг хэмжээгээр давж биелсэн дараах 3 нэр төрлийн орлого байна. Тодруулбал:

- *Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөгөөнөөс 3.9 дахин давж биелжээ.*

Үүнд орлогын төлөвлөгөө батлагдаагүй Дэрэн, Эрдэнэдалай, Адаацаг сумд нийт 412.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Харин Баянжаргалан, Өндөршил, Дэлгэрхангай, Говь-Угтаал, Гурвансайхан, Сайхан-Овоо сумд төлөвлөгөөг 25.1-200.0 хувиар тус тус давуулан биелүүлжээ. Төлөвлөгөө давсан шалтгааныг тодруулахад БОАЖЯ-аас ангийн зөвшөөрлийн төлөвлөгөөг төсөв батлагдсанаас хойш ирүүлдэг, идлэг шонхор шувууг барих төлөвлөгөөнд өөрчлөлт ордогтой тус тус холбоотой байна.

- *Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт 4 дахин давж биелсэн.*

Тайлант онд 50.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 203.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Орлогын төлөвлөгөөг газрын суурь үнээр тооцон төлөвлөдөг ба дуудлага худалдааны явцад газрын үнэ өссөнөөс шалтгаалжээ.

- *Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 4.2 дахин давж биелсэн.*



Ус рашааны нөөц ашигласны төлбөрийг 60.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 252.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн усны тоолуурын заалтад хяналт хийж, 12 дугаар сард 165.9 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн ч 6 нэр төрлийн орлого 2.0-74.0 хувиар тасарсан байна.

Үүнээс материаллаг дүнтэй нь:

- **Үйл ажиллагааны орлогын** төлөвлөгөө нийт дүнгээрээ 15.7 хувиар тасарсан нь Баянжаргалан, Гурвансайхан, Хулд, Луус, Сайнцагаан сумд 8.9-50.8 хувиар тус тус тасалсан нь нөлөөлжээ. Баянжаргалан, Луус Сайнцагаан сум цар тахлын улмаас уул уурхайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа зогссонтой, Хулд сумын төлөвлөгөө өндөр батлагдсантай, Луус сум байгалийн гамшгаас шалтгаалан малын тоо толгой буурсантай, Гурвансайхан сум арьс шир ноосны урамшуулал олгогдоогүйтэй тус тус холбоотой байна.
- **Улсын тэмдэгтийн хураамж** нийт дүнгээрээ 25.3 хувиар тасарсан нь Цагаандэлгэр, Баянжаргалан, Гурвансайхан, Хулд, Сайнцагаан сумд 25.1-61.4 хувиар тус тус тасалсан нь нөлөөлжээ. Баянжаргалан сум улсын тэмдэгтийн хураамжийн орлого тасарсан нь тайлант онд суманд нотариатын үйлчилгээ эрхлэх эрх бүхий албан тушаалтан байхгүй, Цагаандэлгэр сум төлөвлөгөөг өмнөх оноос нэмж баталсан, Хулд сумын аж ахуйн нэгж, байгууллагуудын архи, тамхины тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй зэрэгтэй тус тус холбоотой байна.
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр** 74.0 хувиар тасарсан нь Өндөршил, Өлзийт, Хулд, Эрдэнэдалай сумд орлогын төлөвлөгөөг 37.9-92.5 хувиар тасалсан, харин Адаацаг, Сайнцагаан сумд орлогыг огт төвлөрүүлээгүйтэй холбоотой байна. Сайнцагаан сум түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр огт төвлөрүүлээгүй нь Мэргэжлийн хяналтын газраас “Өлзийт өндөр” ХХК-ны зөвшөөрлийг цуцалсан, шинээр гэрээ байгуулаагүйгээс шалтгаалсан. Хулд, Эрдэнэдалай, Адаацаг сумдад цар тахлын нөхцөл байдлаас болоод иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд шинээр байшин барилга бариагүйтэй холбоотой.

Орлогын төлөвлөгөөг сумд 3.3-108.9 хувиар, нийт дүнгээрээ 17.6 хувиар давуулан биелүүлжээ. Үүнийг сум тус бүрээр харуулбал:

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хүснэгт №6 /сая төгрөгөөр/ Давсан/тасарсан	
				Зөрүү	Хувь
1	Дэлгэрцогт	173.2	212.9	39.7	122.9
2	Дэрэн	190.2	397.3	207.1	208.9
3	Говь-Угтаал	236.8	313.1	76.3	132.2
4	Цагаандэлгэр	140.5	145.2	4.7	103.3
5	Баянжаргалан	255.1	348.4	93.3	136.6
6	Өндөршил	248.9	291.0	42.1	116.9
7	Гурвансайхан	420.2	602.1	181.9	143.3
8	Өлзийт	209.4	269.1	59.7	128.5
9	Хулд	217	265.6	48.6	122.4
10	Луус	206.6	222.5	15.9	107.7
11	Дэлгэрхангай	250.4	271.1	20.7	108.3
12	Сайхан-Овоо	201.9	230.8	28.9	114.3



13	Эрдэнэдалай	454.9	506.5	51.6	111.3
14	Сайнцагаан	1124.7	1,341.2	216.5	119.2
15	Адаацаг	190	233.1	43.1	122.7
16	Мандалговь	3591	3,884.4	293.4	108.2
Нийт дүн		8,110.8	9,534.3	1,423.5	117.6

Дэрэн сум орлогын гүйцэтгэлийг 207.1 сая төгрөг буюу 108.9 хувиар давуулан биелүүлжээ. Орлого давсан шалтгааныг тодруулахад малчдын ноос, арьс ширний урамшуулал жилийн эцэст орсноос үйл ажиллагааны орлого 41.8 хувиар, иргэдийн хадгаламж өссөнөөс хадгаламжийн хүүгийн орлого 42.9 хувиар давж биелсэн. Мөн агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч жилийн эцэст БОАЖЯ-аас эдлэг шонхор, ногтруу шувуу барих тусгай зөвшөөрөл олгож 166.3 сая төгрөг төвлөрүүлсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Хулд, Адаацаг сумдын Эрүүл мэндийн төвүүд ковидын шинжилгээний төлбөрийг харилцах дансанд бүрэн төвлөрүүлээгүй тул хохирлыг нөхөн төлүүлэх 2.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

Цаашид орлогыг хугацаанд нь бүрэн тооцож, төвлөрүүлэх, хяналт тавьж ажиллахыг бүх шатны төсөв захирагч нар анхаарч ажиллах шаардлагатай байна.

2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

2.1 Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ хэмнэлтийн горим зөрчин урсгал зардлыг 5.0 хувиар нэмэгдүүлсэн байна.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас ирүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар, удирдамжийн хүрээнд 2021 оны орон нутгийн төсвийн төслийг нийт 23,823.2 сая төгрөгөөр боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.4.3² дахь заалтад заасны дагуу Сангийн яаманд хүргүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг Сангийн яам 28.0 хувь буюу 6,675.1 сая төгрөгөөр бууруулж, 17,148.1 сая төгрөгөөр хянасан байна.



Дундговь аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 11 дугаар тогтоолоор орон нутгийн 2021 оны төсвийн эх үүсвэр болон зарлагыг 52,569.4 сая төгрөгөөр баталсныг 2021 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 4 дугаар тогтоол болон 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолуудаар тус тус тодотгол хийсэн байна.

Дундговь аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор

² Төсвийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.4.3² дахь хэсэг /Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх/

3,069.5 сая төгрөгөөр, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 0.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн эх үүсвэр болон зарлагыг 55,638.6 сая төгрөг болгон тодотгол хийсэн байна.

Орон нутгийн төсвийг баталсан, тодотгол хийж, өөрчлөлт оруулсан тогтоолуудыг хүснэгтээр харууллаа.


Хүснэгт №7 /сая төгрөгөөр/

Зарцуулах эрх	Өмнөх он	ИТХ-ын тогтоолууд			Зөрүү	
		2020.12.05 №11	2021.08.06 №4	2021.12.03 №20	Өмнөх оноос	Анхны батлагдсанаас
ОНТБ	11,232.6	12,698.1	15,078.8	15,126.6	3,894.0	2,428.5
ОНХС /сумд/	2,170.8	2,522.7	2,522.7	2,522.7	352.0	-
Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	9,553.8	9,456.9	9,412.9	9,365.2	(188.6)	(91.8)
ТЗШБ	28,929.0	27,891.6	28,623.8	28,624.1	(304.9)	732.5
Нийт дүн	51,886.2	52,569.3	55,638.3	55,638.6	3,752.5	3,069.2

Тодотгосон төсвийг өмнөх оны болон анхны батлагдсан төсөвтэй харьцуулахад өмнөх оноос 3,752.5 сая төгрөгөөр, анхны батлагдсан төсвөөс 3,069.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Анхны батлагдсан төсвийг тодотгосон төсөвтэй харьцуулахад орон нутгийн хөрөнгө оруулалтыг 1,305.5 сая төгрөгөөр, орон нутгийн нөөц хөрөнгийг 830.7 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын төсвийг 311.8 сая төгрөгөөр, Хот тохижуулах газрын төсвийг 224.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтыг шинэ хөрөнгө оруулалтад 40.0 сая, тээврийн хэрэгсэлд 125.0 сая, их засварт 460.4 сая, тоног төхөөрөмжид 106.2 сая, төсөл хөтөлбөрт 574.0 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлэн баталжээ.
- Орон нутгийн нөөц хөрөнгийг Корона вируст цар тахал тархсантай холбоотой урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг гамшгийн эрсдэлийг бууруулах зардлуудыг санхүүжүүлэхээр 830.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.
- Засаг даргын Тамгын газрын төсвийг 311.8 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс 103.0 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд, 62.8 сая төгрөгийг урсгал засварын зардалд нэмж баталсан нь материаллаг дүнтэй байна.



Дундговь аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 20 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн байгууллагуудад 15,126.6 сая төгрөг, сумдын ОНХС-гийн шилжүүлэгт 2,522.7 сая төгрөг, сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 9,365.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн

байгууллагуудад 28,624.1 сая төгрөгийг зарцуулахаар тус тус баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсвийн нийт зардлын төлөвлөгөөг 64,265.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Сүүлийн 4 жилийн орон нутгийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад зардлын төлөвлөгөөг өмнөх оноос 6,137.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, зардлын гүйцэтгэл 6,756.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөөний өсөлтийн 85.7 хувь буюу 5,264.3 сая төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Тайлант онд төсвийн нийт зарлагыг дараах зардлуудад зарцуулахаар төлөвлөжээ. Үүнд:



Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн өмнөх оны гүйцэтгэлийг, тайлант оны төлөвлөгөөтэй харьцуулан хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №8 /сая төгрөгөөр/


Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021		Зөрүү /төлөвлөгөө/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэлээс	Тайлант оны гүйцэтгэлээс
Бараа, ажил үйлчилгээний зардал	44,192.6	48,002.2	45,907.7	3,809.6	2,094.5
Татаас ба урсгал шилжүүлэг	1,236.4	1,870.9	1,824.9	634.5	46.0
Хөрөнгийн зардал	2,884.1	12,245.6	7,803.6	9,361.5	4,442.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	1,318.4	2,146.5	851.6	828.0	1,294.9
Нийт дүн	49,631.5	64,265.2	56,387.8	14,633.6	7,877.4

Тайлант оны төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардлыг 3,809.6 сая, татаас ба урсгал шилжүүлгийг 634.5 сая, хөрөнгийн зардлыг 9,361.5 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийг 828.0 сая, нийт 14,633.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Харин тайлант оны төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардлыг 2,094.5 сая, татаас ба урсгал шилжүүлгийг 46.0 сая, хөрөнгийн зардлыг 4,442.0 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийг 1,294.9 сая, нийт 7,877.4 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Тайлант оны төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс 14,633.6 сая төгрөгөөр, тайлант оны гүйцэтгэлээс 7,877.4 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан гүйцэтгэл дутуу зарцуулсантай холбоотой байна.


Төсвийн нийт зардлын төлөвлөгөөг зардлын бүлгээр өмнөх онтой харьцуулан графикаар харууллаа.



Графикаас харахад өмнөх оноос бараа, ажил үйлчилгээний зардал 517.3 сая төгрөг, татаас ба урсгал шилжүүлэг 613.1 сая төгрөг, хөрөнгийн зардал 5,264.3 сая төгрөгөөр тус тус өссөн байхад эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл 257.3 сая төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт

Тайлант онд ОНХС-гийн хөрөнгийг дараах байдлаар баталсан байна.



Дундговь аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-г дараах хөрөнгө оруулалтад зарцуулахаар баталсан байна. Үүнд:



- Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд 2,193.7 сая төгрөг;
- Тоног төхөөрөмжид 1,404.9 сая төгрөг;
- Их засварт 1,149.6 сая төгрөг;
- Төсөл хөтөлбөр арга хэмжээнд 1,078.2 сая төгрөг;

Аймгийн болон сумын ИТХ-аар ОНХС-гийн эх үүсвэрийг 10,835.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 6,695.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Төлөвлөгөө гүйцэтгэлийг сумдаар харууллаа.

Хүснэгт №9 /сая төгрөгөөр/

№	Сумын нэрс	Аймгийн ИТХ-аар баталсан дүн /Төлөвлөгөө/	Гүйцэтгэл
1	Адаацаг сум	118.8	52.6
2	Баянжаргалан сум	872.9	259.4
3	Говь-Угтаал сум	185.1	93.5
4	Гурвансайхан сум	428.4	287.9
5	Дэлгэрхангай сум	332.8	117.1
6	Дэлгэрцогт сум	80.9	51.4
7	Дэрэн сум	131.5	54.8
8	Луус сум	270.8	12.0
9	Өлзийт сум	584.5	279.1
10	Өндөршил сум	395.7	188.9
11	Сайнцагаан сум	318.6	63.5
12	Сайхан-Овоо сум	167.3	70.0
13	Хулд сум	245.6	176.0
14	Цагаандэлгэр сум	140.4	38.2
15	Эрдэнэдалай сум	331.2	154.0
16	Суурь зарлага	211.6	211.6
17	Хот тохижуулах газрын санхүүжилт	192.9	192.9
18	Аймгийн ОНХС	5,826.4	4,392.9
	Дүн	10,835.2	6,695.7

Орон нутгийн хөрөнгө оруулалт

Дундговь аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 11 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтыг 489.1 сая төгрөгөөр баталсныг 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж 1,547.1 сая төгрөг болгон 1,303.5 сая төгрөгөөр өсгөн баталсан байна. Үүнийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №10 /сая төгрөгөөр/

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	ИТХ-ын тогтоол		Зөрүү
		2020.12.05 №11	2021.12.03 №20	
1	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ	113.0	113.0	-
2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	-	40.0	40.0
3	Тоног төхөөрөмж	83.0	314.2	231.2
4	Их засвар	10.0	470.4	460.4
5	Төсөл хөтөлбөр арга хэмжээ	35.6	609.6	574.0
	Нийт дүн	241.6	1,547.2	1,305.6



Дундговь аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолоор аймгийн ОНХО-г дараах хөрөнгө оруулалтад зарцуулахаар баталсан байна. Үүнд:

- Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд 113.0 сая төгрөг;
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 40.0 сая төгрөг;
- Тоног төхөөрөмжид 314.2 сая төгрөг;
- Их засварт 470.4 сая төгрөг;
- Төсөл хөтөлбөр арга хэмжээнд 609.6 сая төгрөг;

Төсөл хөтөлбөрийг нэр төрлөөр нь авч үзвэл аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумдын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдыг чадавхжуулах сургалт, хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр зэрэг арга хэмжээнд нийт 270.0 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.5-д /салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томиолтын зардлыг хэмнэх/ заасантай нийцээгүй бөгөөд төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөх шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт

1. Гурвансайхан сум нь батлагдсан төсвийг сумын ИТХ-ийн шийдвэргүйгээр 10,143.8 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т /*тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх*/; 65 дугаар зүйлийн 65.1.1-т /*тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах*/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн анхны батлагдсан төлөвлөгөөг тодотгосон төсөвтэй харьцуулахад нийт 3,775.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Тодотголын өсөлтийг зардлын зүйлээр харууллаа. Үүнд:

Хүснэгт №11 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэлийн зардлын төлөвлөгөө		Зөрүү
	Анхны	Тодотгосон	
Бараа, үйлчилгээний зардал	46,328.9	48,002.2	1,673.3
Татаас, урсгал шилжүүлэг	1,187.7	1,870.9	683.2
Хөрөнгийн зардал	10,814.5	12,245.6	1,431.1
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан зээл	2,158.5	2,146.6	(12.1)
Нийт дүн	60,489.7	64,265.2	3,775.5

Тодотголоор нэмэгдсэн зардлын 44.3 хувь буюу 1,673.3 сая төгрөг нь бараа, үйлчилгээний зардал байна. Бараа, үйлчилгээний зардлын өсөлтийг зардлын зүйлээр авч үзвэл эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлын өсөлтүүд материаллаг нөлөөлжээ.

Анхны батлагдсан төлөвлөгөөгөөр эд хогшил, урсгал засварын зардал 273.0 сая төгрөг байсныг тодотголоор 1,829.8 сая төгрөг болгож 1,556.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Эд хогшил, урсгал засварын зардалд тавилгын зардлыг 254.6 сая төгрөгөөр нэмж баталсан зэрэг нь Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн



"Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлиггүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/, 1.4-т /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх шаардлагатай байна.

2.2 Төсвийн зарцуулалттай холбоотой нийт зөрчлийн 13.2 хувийг төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтийн горим зөрчин зарцуулсан зөрчил эзэлж байна.

Тус онд төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг 64,265.2 сая төгрөгөөр төлөвлөж, 56,387.9 сая төгрөг буюу 87.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг байгууллагуудаар авч үзэхэд 31.0 хувийг ОНТБ-ууд, 57.1 хувийг ТЗШБ-ууд, 11.9 хувийг ОНХС тус тус эзэлж байна. Байгууллагуудын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №12 /сая төгрөгөөр/

Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт	Хувь
ОНТБ	25,002.0	17,491.5	7,510.5	70.0
ТЗШ	32,568.4	32,206.9	361.6	98.9
ОНХС	6,694.7	6,689.5	5.2	99.9
Нийт дүн	64,265.2	56,387.9	7,877.3	87.7

Төсвийн нийт гүйцэтгэлийг 87.7 хувьтай тайлагнасан нь ОНТБ-уудын төсвийн гүйцэтгэл 70.0 хувьтай буюу төсөл сангийн зарцуулалт бага, зарцуулагдаагүй төсвийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэнтэй тус тус холбоотой байна.

Харин төсвийн гүйцэтгэлийг зардлын бүлгийн дүнгээр авч үзэхэд нийт зардлын 81.4 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 3.2 хувийг татаас, урсгал шилжүүлэг, 7.9 хувийг хөрөнгийн зардал, 1.5 хувийг эргэж төлөгдөх төлбөрийн хассан зээлийн зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт №13 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бараа, ажил үйлчилгээний зардал	48,002.2	45,907.7	2,094.5	95.6
Татаас ба урсгал шилжүүлэг	1,870.9	1,824.9	46.0	97.5
Хөрөнгийн зардал	12,245.6	7,803.6	4,442.0	63.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,146.5	851.6	1,294.9	39.7
Нийт дүн	64,265.2	56,387.8	7,877.3	87.7

Зардлын зүйлээр төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийн гүйцэтгэл бага байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:



- Хөрөнгийн зардал нь Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэл бөгөөд цар тахлын улмаас хил хаагдаж бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн, зарим үйл ажиллагааг хязгаарлаж, цаг хугацааны хувьд хойшлогдсон зэргээс шалтгаалжээ.
- Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор хөрөнгийн зардлын худалдан авалтыг тодорхой хугацаагаар хязгаарласан;
- Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл нь ХХААХҮЯ-ны сайдын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/2191 дугаар албан бичгээр журмын төслийг хэлэлцэж, санал авч байх хугацаанд төсөл сонгон шалгаруулах, зээл олгох үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс түр зогсоох тухай чиглэл ирсэнтэй холбоотой байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3-т */Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах/* заасны дагуу Дундговь аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийг 49,631.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №14 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл		Зөрүү
	2020	2021	
Бараа, ажил үйлчилгээний зардал	44,192.6	45,907.7	1,715.1
Татаас ба урсгал шилжүүлэг	1,236.4	1,824.9	588.5
Хөрөнгийн зардал	2,884.1	7,803.6	4,919.6
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	1,318.4	851.6	(466.9)
Нийт дүн	49,631.5	56,387.8	6,756.3

Өмнөх онтой харьцуулахад төсвийн гүйцэтгэл 6,756.3 сая төгрөгөөр өссөн боловч зардлын нэр төрлөөр авч үзвэл эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл 466.9 сая төгрөгөөр буурсан байна. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийн бууралт нь төсөл сонгон шалгаруулах, зээл олгох үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой байна.

Хөрөнгийн зардал өмнөх оноос 4,919.6 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар 03-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 20 дугаар тогтоолоор хөрөнгийн зардлыг 1,373.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой нийт 1,405.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнээс 95.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 817.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхээр 483.7 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж, аудитын явцад 48.6 сая төгрөгийн залруулга хийлгэж, зөрчлийг арилгасан байна.

Төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг агуулгаар нь ангилан диаграммаар харууллаа.



Нийт зөрчлийн 50.3 хувийг хууль тогтоомж зөрчсөн, 13.2 хувийг төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан, 2.4 хувийг батлагдсан эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан, 34.0 хувийг төсвийн төлөвлөлттэй холбоотой зөрчил тус тус эзэлж байна.

Зардлын данстай холбоотой илэрсэн нийт зөрчил өмнөх оноос 3.4 дахин өссөн үзүүлэлттэй байна. Төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгээс харахад төсвийн хөрөнгийг үрэлгэн, хууль, тогтоомж зөрчин зарцуулсан зөрчлүүд илэрсээр байгаа нь дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Төсвийн үр ашигтай холбоотой:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолоор “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан байна. Тус тогтоолоор Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасан байна.

Гэвч төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус тогтоолыг зөрчсөн дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр тавилга, эд хогшил худалдан авсан;
- Төсвийн хөрөнгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж хөрөнгө зарцуулсан;
- Төсвийн хөрөнгөөр тэмцээн уралдаан, баяр ёслол, сургалт зохион байгуулсан;
- Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг зөрүүтэй тооцоолж олгосон;
- Байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан нэвтрүүлэг бэлтгэсэн.

Дээрх зөрчлүүд нь тус тогтоолын 1.1³, 1.4⁴, 1.5⁵, 1.6⁶, 1.7⁷ заалтуудыг зөрчиж байна.

³ үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой:

Төсөв захирагч нар дулаан үйлдвэрлэгч аж ахуй, нэгж байгууллагатай “Дулааны эрчим хүчээр хангах, худалдан авах тухай гэрээ”-г байгуулахдаа сумдын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцоолон төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулжээ.

Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5.3.1-т */Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр тооцно/* заасныг зөрчсөн байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны халаалтын талбайг талбайн хэмжигдэхүүнээр тооцон гэрээг шинэчлэн байгуулж, төсвийг хэмнэлттэй зарцуулах нь зүйтэй.

Дээрх зөрчлүүд нь дотоод хяналт сул, төсөв захирагч, нягтлан бодогч нарын хууль, эрх зүйн мэдлэг хангалтгүй байгаагаас шалтгаалж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, урсгал зардлыг нэмэгдүүлэх, төсвийн зарцуулалтын үр ашгийг бууруулах үр дагавартай байна.

Дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дээд шатны байгууллагад 2 санал, аймгийн Засаг даргад 3 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

⁴ энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;

⁵ салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;

⁶ Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;

⁷ хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;

2.3 Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 5,907.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,271.4 сая төгрөгийг зарцуулан, 571.1 сая төгрөгийг төвлөрүүлж, 64.7 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн эх үүсвэр



Нэмэлт төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг диаграммаар харуулбал нийт орлогын 43.0 хувийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 12.0 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 7.0 хувийг орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж, 38.0 хувийг эрүүл мэндийн даатгалын

нэмэлт орлого тус тус эзэлж байна.

Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж

Тус онд төсвийн ерөнхийлөн захирагч 431.6 сая төгрөг буюу өмнөх оноос 6.2 дахин их хандив, тусламжийг авч бүртгэл тайланд тусгажээ. Үүнийг байгууллагуудаар харуулбал:

- Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар 418.4 сая төгрөг,
- Соёлын байгууллагууд 6.0 сая төгрөг,
- Боловсролын байгууллагууд 2.5 сая төгрөг,
- Эрүүл мэндийн байгууллагууд 4.7 сая төгрөгийн хандив, тусламжийг тус тус авсан байна.

Хандивын орлого өмнөх оноос 6.2 дахин их, 361.9 сая төгрөгөөр өссөн нь тус онд байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн иргэд, малчдад туслах, Коронавируст цар тахал орон нутагт илэрч, тархсантай холбоотой урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандивыг аймаг, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч, тайлагнасантай холбоотой байна.

Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө

Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,523.0 сая төгрөг төвлөрүүлснийг эх үүсвэрээр нь харууллаа. Үүнд:



- Монгол Улсын Их Хурлаас 120.0 сая төгрөг,
- Яамдаас 284.7 сая төгрөг,
- Төсөвт байгууллагуудаас 1,398.1 сая төгрөг,
- Төсөл хөтөлбөрөөс 719.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Өмнөх оноос 1,122.4 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Их Хурлаас хэлмэгдүүлэлтийн цагаатгалд олгосон нөхөн олговрыг 1,561.0 сая төгрөгөөр бууруулан хуваарилсантай холбоотой байна.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 386.2 сая төгрөг, тухайн жилийн давсан орлого, хэмнэгдсэн зардал 62.7 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 271.6 сая төгрөг, нийт 720.5 сая төгрөгийг эрх нээлгэн зарцуулжээ. Дээрх орлогууд нь өмнөх оноос 430.4 сая төгрөгөөр буюу 1.7 дахин өссөн байна.


Эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого

Тайлант онд сумдын Эрүүл мэндийн төвүүд Коронавируст цар тахалтай холбоотой хэвтэн эмчлүүлсэн болон төлбөртэй үйлчилгээ үзүүлсний төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилж, 4,373.3 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийн тооцоо үүссэнээс 2,232.5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч тайлагнасан байна.

Тайлант оны нэмэлт төсвийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 1,902.4 сая төгрөгөөр өссөн боловч Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлого буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №15 /сая төгрөгөөр/				
№	Нэмэлт төсвийн эх үүсвэр	2020	2021	Өсөлт/ Бууралт
1	Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	69.7	431.6	361.9
2	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,645.4	2,523.0	(1,122.5)
3	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	289.8	720.2	430.4
4	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	2,232.5	2,232.5
Нийт дүн		4,004.9	5,907.3	1,902.4

Нэмэлт төсвийн зарцуулалт



Нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн зардалд 5,842.5 сая төгрөгийг тайлагнаснаас бараа, ажил үйлчилгээний зардалд 3,978.2 сая төгрөг, татаас, урсгал шилжүүлэгт 1,314.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 550.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнийг диаграммаар харууллаа.



Бараа, ажил үйлчилгээний зардал нийт зардлын 68.1 хувийг эзэлж байгаа нь нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалттай холбоотой байна. Нэмэлт санхүүжилтийн тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад өмнөх оноос 2,197.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №16 /сая төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	2020	2021	Өсөлт/ бууралт
1	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,726.3	3,978.2	1,251.9
2	Татаас, урсгал шилжүүлэг	38.6	1,314.1	1,275.5
3	Хөрөнгийн зардал	879.6	550.2	(329.4)
	Нийт дүн	3,644.5	5,842.5	2,197.9

Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтийн дийлэнх хувийг нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд тус тус эзэлж байна. Энэ нь Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа үйлчилгээний бусад зардлыг өсгөснөөс шалтгаалсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Өмнөх оны орлогын төлөвлөгөө давж биелсэн ч торгуулийн орлого, хадгаламжийн хүүгийн орлого, дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын орлого, хөрөнгө борлуулсны орлогыг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлээс бууруулан баталсан байна.
2. Тайлант хугацаанд 6,551.7 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,793.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 119.0 хувь буюу 1,242.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
3. Анхны батлагдсан төсвөөр эд хогшил, урсгал засварын зардал 273.0 сая төгрөг байсныг тодотголоор 1,829.8 сая төгрөг болгон баталж, 1,556.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон нь урсгал зардлыг 5 хувиар өсгөжээ.
4. Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой нийт 1,405.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.4 дахин өссөн байна. Нийт зөрчлийн 50.3 хувийг хууль тогтоомж зөрчсөн, 13.2 хувийг төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан, 2.4 хувийг батлагдсан эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан, 34.0 хувийг төсвийн төлөвлөлттэй холбоотой зөрчил тус тус эзэлж байна.
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

- Орлогыг төлөвлөхдөө тухайн тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх онд орсон нэг удаагийн шинж чанартай орлого зэргийг тооцон, орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;
- Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ Төсвийн тухай хуульд заасан нөхцөл шаардлагыг харгалзан, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөх;
- “Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн, төсвийг хэмнэлттэй зарцуулах;
- Харилцагч байгууллагуудтай хуулийн дагуу гэрээ байгуулж, гэрээний дагуу үйл ажиллагааг явуулах чиглэлийг бүх шатны төсөв захирагч нарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн төсвийн зарцуулалттай холбоотой зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжээс тавих хяналтыг сайжруулах, байгууллагуудын нягтлан бодогч, төсөв захирагч нарыг чадавхжуулах, хууль эрх зүй, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна.

Нөхцөл байдал:

2019, 2021 онуудад Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоол гарч хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэмэгдүүлэн тогтоосонтой холбоотой батлагдсан төсвийг хэтрүүлсэн, дулаанаар хангагч байгууллагатай өр, авлагын тооцоо нийлээгүй, зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь/төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх./ заалтыг зөрчсөн.

Санал:

Эрчим хүчний зохицуулах хороо нь аж ахуйн нэгж, байгууллагын саналын дагуу үнэ тарифыг өөрчлөх бус эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан үнийн тарифыг тогтоож байх талаар Эрчим хүчний зохицуулах хороонд зөвлөмж хүргүүлэх саналтай байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР

Дундговь аймгийн засаг даргаас ирүүлсэн санал, тайлбар

Санал 1

Тайлбар 1

Саналд дурдсан агуулга аудитын тайлангийн бүлэг 1.1-т бичигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.

Санал 2

Тайлбар 2

Тайлангийн 2.1-т тодотголоор Коронавируст цар тахлын эрсдэлийг бууруулахаас гадна материаллаг нэмэгдсэн байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ, зардлын зүйлийг тодорхой оруулсан тул тайлангийн агуулгад өөрчлөлт оруулаагүй, найруулгыг өөрчилсөн.

Санал 3

Тайлбар 3

Аудитын тайлангийн бүлэг



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын ордон,
7 дугаар баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090,
Утас/Факс: (976) 7059 2353, Цахим шуудан: info@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2022.04.22 № 01/584
танай _____-ны № _____-т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Т. Оюун-Эрнэл
Тайлбарын үргэлжлэл,
тайлбарын үргэлжлэл
R 15/02

Хариу тайлбар хүргүүлэх тухай

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой дараах асуудлууд дээр тайлбар хүргүүлж байна. Үүнд:

1. Төсвийн орлогыг бүрэн бүрдүүлэх, төлөвлөлтийг суурь судалгаа, гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн. Дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын орлого, хөрөнгө борлуулсны орлого нь жил бүр харилцан адилгүй, жил бүр өсөн нэмэгдүүлж батлах боломжгүй.

2. Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ хэмнэлтийн горим зөрчин урсгал зардлыг нэмэгдүүлсэн гэжээ. 2021 онд төсөвт 2 удаа тодотгол хийсэн. Энэ нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үед аймаг, суманд тооцож төлөвлөсөн хөрөнгө дутмаг, гарах зардлыг урьдчилан тооцох боломжгүй байсан бөгөөд Улсын Онцгой Комисс, Аймгийн Онцгой Комиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэхийн тулд зарим хөрөнгө оруулалтын ажлыг царцааж "Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7^{1.1} дэх заалтаар олгосон эрх хэмжээний хүрээнд Аймгийн орон нутгийн хөгжлийн санд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн зохицуулалт хийлгүүлж, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тандалт судалгааны урсгал зардлуудад зарцуулсан. Энэ нь төсвийн хэмнэлтийн горимыг зөрчөөгүй төдийгүй цаг үеийн нөхцөл байдалд зайлшгүй шийдвэрлэх зардлыг хуулийн хүрээнд зарцуулсан.

3. 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар Монгол улсын 2021 оны төсөвт тодотгол хийсний улмаас аймгийн төсөвт тодотгол хийсэн. Уг тодотголоор оны эхний үлдэгдэл, орон нутгийн төсвөөс 1,303.5 сая төгрөг, Ковид-19 цар тахалтай холбогдох зардалд 829,1 сая төгрөг, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 2021 онд боловсролын салбарын албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг Боловсролын газраас олгохоор шийдвэрлэн аймагт уг зардлыг олгоогүй байсан бөгөөд тодотголоор аймагт 732,1 сая төгрөгийг нэмэгдүүлж тус тус тодотгол хийсэн. Уг тодотголд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн асуудал байхгүй бөгөөд хууль тогтоомжийн дагуу төсвийн тодотголыг хийсэн байхад төсвийг хэмнэлгүй, холбогдох хууль тогтоомжийг зөрчих үр дагавартай гэсэн дүгнэлттэй санал нийлэхгүй байна. Ковид цар тахалтай тэмцэх ажил, арга хэмжээнд хөрөнгө бүрдүүлэх зорилгоор аймаг, сумдын баяр наадмыг тэмдэглэхгүй байх захирамж гарган 74,4 сая төгрөгийг цар тахалд зарцуулсан. Цар тахлын нөхцөл байдалд төсвийн боломжит зардлыг хэмнэх, төсвийн

2.2-т төсвийн зарцуулалттай холбоотой өмнөх оны дүнтэй харьцуулсан бөгөөд илэрсэн зөрчлийг жагсаалтыг хавсралт №3-т орууллаа.

бус эх үүсвэр хандив тусламжийг хүлээн авах ажлыг зохион байгуулж хууль журмын дагуу зарцуулж тайлагнан цар тахлын зарим зардлыг шийдвэрлэсэн зэрэг цаг үеийн онцлогтой нөхцөл байдал тайлант онд үүссэнг харгалзан үзэх нь зүйтэй байна.

Мөн түүнчлэн төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил өмнөх оноос 3,4 дахин өсөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтийн горим зөрчин зарцуулсан гэсэн дүгнэлт нь тодорхой бус, нотлох баримтгүй байгаа тул тайлант оны төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтан, зөрчлийн агуулга, зөрчлийн дүнгээр дэлгэрэнгүй тайлан мэдээлэл гаргаж танилцуулах нь бидний цаашдын ажилд дэмжлэг болох тул дээрх мэдээллийг гаргаж ирүүлэхийг хүсье.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ



ХАВСРАЛТ

Хавсралт №1

НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,265,157,500.00	56,387,850,843.27	7,877,306,656.73	87.7
УРСГАЛ ЗАРДАЛ	49,873,108,400.00	47,732,644,979.97	2,140,463,420.03	95.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,002,210,400.00	45,907,725,080.37	2,094,485,319.63	95.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,691,572,600.00	28,386,356,507.67	305,216,092.33	98.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,750,807,200.00	3,676,482,286.48	74,324,913.52	98.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,808,743,200.00	4781625804.68	27,117,395.32	99.4
Хангамж, бараа материалын зардал	1,427,279,500.00	1,413,397,967.66	13,881,532.34	99.0
Нормативт зардал	1,432,052,700.00	1,343,437,484.43	88,615,215.57	93.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,829,780,300.00	1,758,072,987.75	71,707,312.25	96.1
Томилолт, зочны зардал	228,882,500.00	214,115,010.00	14,767,490.00	93.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,157,830,600.00	1,148,759,828.39	9,070,771.61	99.2
Бараа үйлчилгээний бусад зардал	4,566,653,400.00	3,085,519,649.51	1,481,133,750.49	67.6
ТАТААС	406,899,800.00	406,899,800.00		100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	109,300,000.00	109,300,000.00		100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	109,300,000.00	109,300,000.00		100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	297,599,800.00	297,599,800.00		100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	297,599,800.00	297,599,800.00		100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,463,998,200.00	1,418,020,099.60	45,978,100.40	96.9
Бусад урсгал шилжүүлэг	1,463,998,200.00	1,418,020,099.60	45,978,100.40	96.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,245,591,000.00	7,803,628,943.30	4,441,962,056.70	63.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,146,458,100.00	851,576,920.00	1,294,881,180.00	39.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,265,157,500.00	57,823,192,109.39	6,441,965,390.61	90.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,909,231,500.00	34,758,162,830.83	151,068,669.17	99.6
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,234,113,300.00	20,149,434,236.88	1,084,679,063.12	94.9
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	409,224,300.00	215,199,010.00	194,025,290.00	52.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,712,588,400.00	2,700,396,031.68	5,012,192,368.32	35.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,839,275,108.05	(5,839,275,108.05)	



Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,292,486,198.17	(7,292,486,198.17)	
---	--	------------------	--------------------	--

Хавсралт №2

НЭГТГЭСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/

	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,842,509,323.43
УРСГАЛ ЗАРДАЛ	5,292,334,057.43
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,978,150,681.78
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,744,695.16
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,331,748.24
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,090,682.52
Хангамж, бараа материалын зардал	302,633,769.50
Нормативт зардал	1,294,551,808.34
Эд хогшил, урсгал засварын зардал	329,693,665.00
Томилолт, зочны зардал	9,551,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	342,179,626.50
Бараа үйлчилгээний бусад зардал	1,075,373,486.52
ТАТААС	245,439,300.52
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	245,439,300.52
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,068,744,075.13
Бусад урсгал шилжүүлэг	497,620,270.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	571,123,805.13
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	550,175,266.00
Дотоод эх үүсвэрээр	550,175,266.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,907,254,067.09
Нэмэлт санхүүжилтийн орлого	5,907,254,067.09
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	64,744,743.66
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	424.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	64,745,168.16

Төсвийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчлийн жагсаалт

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн утга	Шийдвэрлэсэн байдал	Нийт алдаа зөрчил		Зөрчлийн ангилал
				Тоо	Дүн	
1	ЦД ИТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хүнс авч, зориулалт бусаар зарцуулсан.	Албан шаардлага	1	150.1	Төсвийн төлөвлөлт
2	ЦД ЗДТГ	Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог нормоор бодож баримтжуулаагүй.	Албан шаардлага	1	27,185.1	Хууль тогтоомж
3	ЦД ЗДТГ	Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг илүү олгосон.	Албан шаардлага	1	1,172.6	Төсвийн үр ашиг
4	ЦД СХС	Цагаандэлгэр сумын төсөл хэрэгжүүлэгч нь гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс санд хохирол учруулсан.	Төлбөрийн акт	5	42,524.6	Хууль тогтоомж
5	ЦД ОНХС	Сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад ороогүй, иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Санхүүгийн программын сунгалт” -ын зардлыг санхүүжүүлсэн.	Төлбөрийн акт	1	240.0	Зориулалт бус
6	БЖ ИТХ	Байгууллагын албан хэрэгцээнд морин хуур, шүүгээ худалдан авч, хэмнэлтийн тогтоол зөрчсөн.	Албан шаардлага	1	2,580.0	Төсвийн үр ашиг
7	БЖ ЗДТГ	ЗД-ын нөөц сангаас шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулж хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	1,000.0	Төсвийн үр ашиг
8	БЖ ЗДТГ	Төсвөөс тавилга эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	7,538.0	Төсвийн үр ашиг
9	БЖ ЭМТ	Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог нормоор бодож баримтжуулаагүй.	Залруулсан алдаа	1	10,230.1	Хууль тогтоомж
10	БЖ ЕБС	Байгууллагын ажилчдад дархлаа дэмжих хүнсийг олгож хөдөлмөр нийгмийн хамгааллын зардлаас төлсөн.	Албан шаардлага	1	1,450.0	Зориулалт бус
11	БЖ СӨБ	Аудитаар хэмнэлтийн горим зөрчиж тавилга худалдан авсан.	Албан шаардлага	1	1,478.0	Төсвийн үр ашиг
12	ӨШ ИТХ	Цалингийн зардлаас суутгах нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлсөн.	Албан шаардлага	1	234.1	Зориулалт бус
13	ӨШ ЗДТГ	Засаг даргын нөөц сангаас хил залгаа сумдтай тэмцээн зохион байгуулж хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	2,000.0	Төсвийн үр ашиг
14	ӨШ ЗДТГ	Улаанбаатар хотод бүх ажилчдыг "Хүний хөгжил" сургалтад хамруулж албан томилолтын зардал олгож хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	2,622.0	Төсвийн үр ашиг
15	ӨШ ЭМТ	Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгож, албан томилолтын зардлаас илүү тооцож олгосон.	Төлбөрийн акт	1	63.0	Төсвийн үр ашиг

16	ӨШ ЭМТ	Төсвөөс тавилга эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	9,063.0	Төсвийн үр ашиг
17	ӨШ ЕБС	Даатгуулагчаас төлөх шимтгэлийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас төлсөн.	Залруулсан алдаа	1	61.2	Зориулалт бус
18	ӨШ ЕБС	Төсвөөс тавилга эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	2,234.0	Төсвийн үр ашиг
19	ӨШ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
20	ӨШ СӨБ	Үр дүнгийн тайланд үндсэн цалингийн зардлыг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаар тайлагнасан.	Залруулсан алдаа	1	115.1	Хууль тогтоомж
21	ӨШ ОНХС	Сумын ОНХС-ийн хөрөнгийг сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, олон нийтийн эрх ашигт нийцээгүй буюу зориулалт бус “Хүний нөөцийн хөтөлбөрийн санхүүжилт” гэх төсөл арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн.	Албан шаардлага	1	10,000.0	Хууль тогтоомж
22	СЦ ИТХ	Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдлийг илүү олгосон.	Албан шаардлага	2	2,383.4	Төсвийн үр ашиг
23	СЦ ЗДТГ	Засаг даргын нөөц сангаас тэмцээн зохион байгуулж хэмнэлтийн горим зөрчсөн.	Төлбөрийн акт	1	3,296.0	Төсвийн үр ашиг
24	СЦ ЗДТГ	Бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн.	Албан шаардлага	1	1,916.6	Хууль тогтоомж
25	СЦ ЭДЦС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
26	СЦ ГИЦС	Сургуулийн захирал ээлжийн амралтаараа төрсөн нутагтаа очиж амрах замын зардал илүү олгосон	Төлбөрийн акт	1	165.4	Төсвийн үр ашиг
27	СЦ ГИЦС	Сургуулийн 58 ажилчдын ээлжийн амралтын мөнгийг зөрүүтэй тооцож олгосон	Төлбөрийн акт	1	2,031.3	Төсвийн үр ашиг
28	СЦ ГИЦС	Ажилтнуудад ажлын хувцас захиалахдаа барилгын материалын дэлгүүрээр дамжуулан бэлнээр гарган авч, жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хувцсыг байгаагаар тоолж, баталгаажуулсан	Төлбөрийн акт	1	3,000.0	Төсвийн үр ашиг
29	СЦ ГИЦС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн;	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
30	СЦ ГИЦС	Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин шагнал, урамшуулал, уралдаан тэмцээнд зарцуулсан	Албан шаардлага	1	2,435.7	Төсвийн үр ашиг
31	СЦ ХС	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас зарцуулсан	Албан шаардлага	1	6,979.9	Зориулалт бус
32	СЦ ЦБС	Хэмнэлтийн горим зөрчиж тавилга худалдан авсан.	Албан шаардлага	1	2,150.0	Төсвийн үр ашиг
33	СЦ ЦБС	Тэтгэвэрт гарсан хүнийг төрийн албан хаагчаар томилж, цалингийн нэмэгдэл, урамшууллыг олгосон байна.	Албан шаардлага	1	6,434.5	Төсвийн үр ашиг
34	СЦ МС	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд тушаалаар шагнал нөхөн олгосон	Төлбөрийн акт	1	621.1	Төсвийн үр ашиг
35	СЦ 1-р цэцэрлэг	Хоол хүнсний зардлаас анхан шатны баримтгүйгээр 88,705.00 төгрөгийн хоолны	Төлбөрийн акт	1	88.7	Хууль тогтоомж

		материал зарцуулсан.				
36	СЦ 2-р цэцэрлэг	Цалингийн зардлаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлөх зардлаас төлсөн.	Албан шаардлага	1	202.6	Зориулалт бус
37	СЦ 2-р цэцэрлэг	Хэмнэлтийн горим зөрчиж тавилга худалдан авсан.	Албан шаардлага	1	560.0	Төсвийн үр ашиг
38	СЦ 4-р цэцэрлэг	Цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийг төлсөн	Албан шаардлага	1	1,291.7	Зориулалт бус
39	СЦ 5-р цэцэрлэг	Хэмнэлтийн горим зөрчиж тавилга худалдан авсан.	Албан шаардлага	1	2,520.0	Төсвийн үр ашиг
40	СЦ ОНХС	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Хот тохижуулах газрын үйл ажиллагаа явуулах барилга”-ын засварын ажлын төсвийг 2 хуваан баталж, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг буруу сонгож, босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн.	Албан шаардлага	1	31,772.4	Хууль тогтоомж
41	ГУ ЕБС	Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	Төлбөрийн акт	1	159.8	Төсвийн үр ашиг
42	ГУ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
43	ГУ СӨБ	Халаалтын төлбөрийг нэхэмжлэхээс илүү дүнгээр төлсөн	Залруулсан алдаа	1	928.1	Төсвийн үр ашиг
44	ГУ ЭМТ	Хүнсний материалыг хоолны ордер хөтлөлгүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарцуулсан.	Залруулсан алдаа	1	780.1	Хууль тогтоомж
45	ГУ ЭМТ	Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон.	Төлбөрийн акт	1	128.0	Төсвийн үр ашиг
46	ГУ ЭМТ	Тээвэр шатахууны зардлаас жин баталгаажуулалтын үнэ төлсөн.	Албан шаардлага	1	47.4	Зориулалт бус
47	ГУ ЗДТГ	Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог нормоор бодож баримтжуулаагүй.	Залруулсан алдаа	1	18,735.9	Хууль тогтоомж
48	ГУ ЗДТГ	Урсгал засварын зардлаас бүрдэл дутуу анхан шатны баримтаар хөрөнгө зарцуулсан.	Албан шаардлага	1	9,892.0	Хууль тогтоомж
49	ГУ ЗДТГ	Байгууллагын албан хэрэгцээнд тавилга худалдан авч, хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	7,018.8	Төсвийн үр ашиг
50	ГУ ЗДТГ	Тавилга эд хогшлын зардлаас тоног төхөөрөмж худалдан авсан.	Албан шаардлага	1	901.9	Төсвийн үр ашиг
51	ГУ ОНХС	ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад эдийн засгийн тооцоо судалгаа, зураг төсөв нь хийгдээгүй 18 нэр төрлийн 190,649,100.00 төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталсан	Албан шаардлага	1	190,649.1	Хууль тогтоомж
52	ГУ ТЗС	Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	Албан шаардлага	1	318.7	Төсвийн үр ашиг
53	ГУ ТТЗ	Эд хогшил, урсгал засварын зардал 10,969.0 мянган төгрөг байсныг тодотголоор 135,025.4 мянган төгрөг болгож 124,056.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан.	Зөвлөмж	1	124,056.4	Төсвийн төлөвлөлт
54	ГС ЕБС	Шуудан холбооны зардлаас "Интернэтийн хурд сайжруулах тоног төхөөрөмж", Урсгал засварын зардлаас "Газын плитка, баллон, газ, дагалдах хэрэгсэл" худалдаж авсан.	Албан шаардлага	1	454.0	Зориулалт бус
55	ГС ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж

56	ГС СӨБ	Үр дүнгийн урамшууллыг илүү олгосон	Төлбөрийн акт	1	237.8	Төсвийн үр ашиг
57	ГС СӨБ	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас санхүүжүүлсэн	Албан шаардлага	1	2,293.2	Зориулалт бус
58	ГС СОЁЛ	Байгууллагын албан хэрэгцээнд сандал ширээ, номын шүүгээ худалдан авч, хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	2,484.3	Төсвийн үр ашиг
59	ГС ЭМТ	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас зарцуулсан.	Албан шаардлага	1	915.1	Зориулалт бус
60	ГС ЗДТГ	Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан.	Албан шаардлага	1	5,537.0	Хууль тогтоомж
61	ГС ЗДТГ	Дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагатай халаалтын гэрээг байгуулахдаа батлагдсан төсвөөс хэтрүүлэн байгуулсан.	Зөвлөмж	1	2,974.6	Хууль тогтоомж
62	ГС ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр тавилга, эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	17,049.0	Төсвийн үр ашиг
63	ГС ЗДТГ	Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг илүү олгосон	Албан шаардлага	1	2,706.3	Хууль тогтоомж
64	ГС ЗДТГ	Аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандивыг ОНХС-гийн дансанд төвлөрүүлэлгүй, зориулалт бусаар зарцуулсан.	Албан шаардлага	1	10,000.0	Зориулалт бус
65	ГС ЗДТГ	Төсвийг орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээнд бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.	Төлбөрийн акт	1	1,500.0	Төсвийн үр ашиг
66	ГС ИТХ	Тавилга худалдан авч, хэмнэлтийн тогтоол зөрчсөн.	Албан шаардлага	1	430.0	Төсвийн үр ашиг
67	ГС ОНХС	“SSS комплекс шалны засвар”-ын ажлыг гүйцэтгэх гэрээг 200.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн байгуулсан.	Албан шаардлага	1	200.0	Төсвийн үр ашиг
68	ГС ОНХС	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Спорт байгууламжийн дээвэр, SSS комплекс шалны засвар, Соёлын төвийн хананы засвар” нэг барилгын ажлыг 3 хуваан баталж, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг буруу сонгож босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн.	Албан шаардлага	1	59,000.0	Хууль тогтоомж
69	ГС СХС	Гурвансайхан сумын нэр бүхий 2 төсөл хэрэгжүүлэгч гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүйгээс Сум хөгжүүлэх санд хохирол учруулсан байна.	Төлбөрийн акт	2	24,761.1	Хууль тогтоомж
70	ГС ТТЗ	Эд хогшил, урсгал засварын зардал 10,988.1 мянган төгрөг байсныг тодотголоор 118,088.3 мянган төгрөг болгож 107,100.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан.	Зөвлөмж	1	107,100.2	Төсвийн төлөвлөлт
71	ГС ТТЗ	Батлагдсан төсвийг сумын ИТХ-ийн шийдвэргүйгээр бууруулан тайлагнасан.	Зөвлөмж	1	10,143.8	Төсвийн төлөвлөлт
72	ДЦ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж

73	ДЦ ЭМТ	Вакцины урамшууллыг олгоходоо тооцоолол хийгээгүй, анхан шатны баримтгүй зарцуулсан.	Албан шаардлага	1	4,570.9	Хууль тогтоомж
74	ДЦ ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар хөрөнгө зарцуулсан.	Албан шаардлага	1	5,208.0	Төсвийн үр ашиг
75	ДЦ ЗДТГ	Тушаал шийдвэргүйгээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.	Албан шаардлага	1	262.1	Төсвийн үр ашиг
76	ДЦ ЗДТГ	Зарцуулсан шатахууны тооцоог бодож баталгаажуулаагүй санхүүгийн тайланд зардлаар тайлагнасан	Албан шаардлага	1	14,115.5	Хууль тогтоомж
77	ДЦ ИТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хүнс авч, зориулалт бусаар зарцуулсан.	Албан шаардлага	1	62.5	Зориулалт бус
78	ДЦ СХС	Дэлгэрцогт сумын төсөл хэрэгжүүлэгч нь гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Сум хөгжүүлэх санд хохирол учруулсан.	Төлбөрийн акт	1	7,388.1	Хууль тогтоомж
79	ДЭ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
80	ДЭ СӨБ	Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг баримталж ажиллаагүй.	Зөвлөмж	1	94.4	Хууль тогтоомж
81	ДЭ СОЁЛ	Тавилга худалдан авч, хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	3,290.0	Төсвийн үр ашиг
82	ДЭ ЭМТ	Бараа үйлчилгээний бусад зардлаас ажилчдад дархлаа дэмжих зорилгоор олгосон бүтээгдэхүүнд амттан оруулж, төсвийг хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан.	Төлбөрийн акт	1	135.0	Төсвийн үр ашиг
83	ДЭ ЭМТ	Ажилчдад урамшуулал олгоходоо хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн татварын хөнгөлөлт эдлүүлсэн.	Төлбөрийн акт	1	551.0	Төсвийн үр ашиг
84	ДЭ ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр тавилга, эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	4,983.0	Төсвийн үр ашиг
85	ДЭ ИТХ	Байгууллагын албан хэрэгцээнд тавилга худалдан авч, хэмнэлтийн тогтоол зөрчсөн.	Албан шаардлага	1	5,589.9	Төсвийн үр ашиг
86	ДЭ ТТЗ	Эд хогшил, урсгал засварын зардал 10,969.0 мянган төгрөг байсныг тодотголоор 82,843.6 мянган төгрөг болгож 71,874.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж хэмнэлтийн горим зөрчсөн.	Зөвлөмж	1	71,874.6	Төсвийн төлөвлөлт
87	ӨЛ ИТХ	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас суутгах нийгмийн даатгалын шимтгэлийг үндсэн цалингийн зардлаас төлсөн.	Албан шаардлага	1	38.9	Зориулалт бус
88	ӨЛ ЗДТГ	Тавилга эд хогшил, ажлын хувцас худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	16,494.9	Төсвийн үр ашиг
89	ӨЛ ЗДТГ	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас зарцуулсан.	Албан шаардлага	1	386.1	Төсвийн үр ашиг
90	ӨЛ ЭМТ	Ажлаас гарсан болон ажилд шинээр орсон 2 ажилтанд ковидын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эмч, албан хаагчдад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгосон.	Төлбөрийн акт	1	400.0	Төсвийн үр ашиг
91	ӨЛ ЭМТ	Цалингийн зардлаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас зарцуулсан	Албан шаардлага	1	1,453.0	Зориулалт бус

92	ӨЛ ЕБС	Цалингийн зардлаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас зарцуулсан.	Албан шаардлага	1	2,410.6	Зориулалт бус
93	ӨЛ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
94	ӨЛ ОНХС	2021 онд төсөвт тодотгол хийж иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, “Гамшгийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ны урсгал зардлыг санхүүжүүлсэн.	Албан шаардлага	1	18,553.9	Хууль тогтоомж
95	ӨЛ ТТЗ	Сумын ИТХ-ын 2021 оны 09 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 53,906.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 64,942.1 мянган төгрөг болгон баталж Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолыг зөрчсөн	Зөвлөмж	1	53,906.1	Төсвийн төлөвлөлт
96	ХУ ИТХ	Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд анхан шатны баримтаас зөрүүтэй тайлагнасан.	Албан шаардлага	1	944.2	Хууль тогтоомж
97	ХУ ЗДТГ	Төсвөөс 600.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил авч, 1,500.0 мянган төгрөгийг сургалт, шагнал, урамшуулалд зарцуулан хэмнэлтийн горимыг зөрчсөн.	Албан шаардлага	1	2,100.0	Төсвийн үр ашиг
98	ХУ ЗДТГ	Эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон Төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг илүү олгосон.	Албан шаардлага	1	2,132.0	Төсвийн үр ашиг
99	ХУ ЭМТ	Аудитаар ковидын шинжилгээний төлбөр 1,967,000 төгрөгийн орлогыг харилцах дансанд тушаагаагүй, бэлэн мөнгөний үлдэгдэлд тайлагнаагүй, дутаасан.	Төлбөрийн акт	1	1,967.0	Төсвийн үр ашиг
100	ХУ ЭМТ	Албаны машиныг хувьдаа ашиглаж, анхан шатны баримтгүй 2,001,200 төгрөгийн шатахууны зардал гаргасан.	Төлбөрийн акт	1	2,001.2	Төсвийн үр ашиг
101	ХУ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
102	ХУ СӨБ	Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлэн ажиллуулсан.	Албан шаардлага	1	3,487.2	Төсвийн үр ашиг
103	ХУ ОНХС	Сангийн хөрөнгийг иргэд олон нийтийн саналаар дэмжигдээгүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Гамшгийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ” - ний урсгал зардалд зарцуулсан.	Албан шаардлага	1	9,997.2	Хууль тогтоомж
104	ХУ ТЗС	Байгаль хамгаалах сангаас 2021 оны байгаль хамгаалах сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулалгүй 14,609,950.00 төгрөгийг зарцуулсан	Албан шаардлага	1	14,610.0	Төсвийн төлөвлөлт
105	ХУ ТТЗ	Сумын ИТХ-ын 2021 оны 09 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 52,525.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 63,240.0 мянган төгрөг болгон баталж Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолыг зөрчсөн	Зөвлөмж	1	58,900.2	Төсвийн төлөвлөлт
106	АД ИТХ	Аудитаар хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдлийг илүү олгосон.	Албан шаардлага	1	1,132.7	Төсвийн үр ашиг

107	АД ЗДТГ	Орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг 4, 6, 9 саруудад хавсарган гүйцэтгэж, ажил хавсарсны нэмэгдэл цалин бодож олгосон.	Албан шаардлага	1	581.9	Төсвийн үр ашиг
108	АД ЗДТГ	Төсвөөс хэмнэлтийн ЗГ-ын 43-р тогтоолыг зөрчиж, тэмдэглэлт ой, урлагийн наадам, уралдаан тэмцээнд 4,217.0 мянган төгрөгийг зарцуулсан.	Албан шаардлага	1	4,217.0	Төсвийн үр ашиг
109	АД ЗДТГ	Адаацаг сумын хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон Төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг 10 хувиар буюу 794,696 төгрөгөөр илүү олгосон.	Албан шаардлага	1	794.7	Төсвийн үр ашиг
110	АД ЭМТ	Ковидын шинжилгээний төлбөрийг дутуу төвлөрүүлсэн.	Төлбөрийн акт	1	606.0	Төсвийн үр ашиг
111	АД ЭМТ	Орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, ажил хавсарсны нэмэгдэлд 3,135,264 төгрөгийн цалин бодож олгосон.	Албан шаардлага	1	3,135.3	Төсвийн үр ашиг
112	АД ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
113	АД СӨБ	Цалингийн зардлаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлөх зардлаас төлсөн.	Албан шаардлага	1	393.4	Зориулалт бус
114	АД Соёл	Байгууллагын албан хэрэгцээнд сандал ширээ худалдан авч, хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	1,850.0	Төсвийн үр ашиг
115	АД ОНХС	Төсөвт тодотгол хийж иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Гамшгийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ” - ний урсгал зардлыг санхүүжүүлсэн.	Албан шаардлага	1	9,290.0	Хууль тогтоомж
116	АД ТТЗ	Сумын ИТХ-ын 2021 оны 09 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 52,525.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 63,240.0 мянган төгрөг болгон баталж Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолыг зөрчсөн	Зөвлөмж	1	52,525.0	Төсвийн төлөвлөлт
117	ЛУ ИТХ	Шуудан холбоо, интернэтийн төлбөрөөс нэгжийн мөнгө олгосон	Төлбөрийн акт	1	40.0	Зориулалт бус
118	ЛУ ЕБС	Төсвийн хөрөнгөөр нүүрс худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, төсвийг хяналтгүй зарцуулсан.	Албан шаардлага	1	2,400.0	Хууль тогтоомж
119	ЛУ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
120	ЛУ ЭМТ	Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж урамшуулал авсан.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
121	ДХ Соёл	Тоног төхөөрөмж худалдан авахад худалдах, худалдан авах гэрээ хийгээгүй, цахим баримтыг бүрдүүлээгүй	Зөвлөмж	1	1,850.0	Хууль тогтоомж
122	ДХ ЭМТ	Өндөр насны тэтгэвэр тогтоолгоод үргэлжлүүлэн ажиллаж байгаа ажилтанд байгууллагаас түлшний хөнгөлөлт давхардуулан олгосон.	Төлбөрийн акт	1	163.3	Төсвийн үр ашиг
123	ДХ ЭМТ	Албан томилолттой албан хаагчдад хоолны мөнгө давхардуулан олгосон.	Залруулсан алдаа	1	23.0	Төсвийн үр ашиг

124	ДХ ЕБС	Ээлжийн амралтын олговрын авлагыг цалингийн нийгмийн даатгалын шимтгэл, татварын зардлаас үүсгэсэн.	Залруулсан алдаа	1	25,984.6	Төсвийн үр ашиг
125	ДХ ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
126	СО ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
127	СО ЗДТГ	Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг илүү олгосон	Албан шаардлага	1	2,936.2	Төсвийн үр ашиг
128	СО ЭМТ	Гаднын машинтай гэрээ хийлгүй, анхан шатны баримт дутуу, шатахууны зарим зөвшөөрлийн хуудаст тамга тэмдэг дараагүй, түлш, шатахууныг зарцуулсан.	Албан шаардлага	1	2,855.6	Төсвийн үр ашиг
129	ЭР ИТХ	Аудитаар хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдлийг илүү олгосон зөрчил илэрлээ.	Албан шаардлага	1	853.4	Төсвийн үр ашиг
130	ЭР ЗДТГ	Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг илүү олгосон	Албан шаардлага	1	3,536.4	Төсвийн үр ашиг
131	ЭР ОНХС	"Гамшгийн эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээ" "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангах дэд хөтөлбөр" иргэдийн санал аваагүй төсөл хөтөлбөр санхүүжүүлсэн	Албан шаардлага	1	70,000.0	Хууль тогтоомж
132	ЭР ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
133	Музей	Тушаал шийдвэргүй хөрөнгө зарцуулсан.	Зөвлөмж	1	276.0	Төсвийн үр ашиг
134	БОАЖ	Тэтгэвэрт гарсан ажилтанд хөдөлмөрийн гэрээнд тусгагдаагүй нэмэгдэл цалин бодож, олгосон.	Албан шаардлага	1	449.9	Төсвийн үр ашиг
135	БТСГ	Ажилтанд үр дүнгийн урамшуулалт цалинг 2 удаа олгосон боловч тайланд авлагаар тусгаагүй.	Залруулсан алдаа	1	233.7	Төсвийн үр ашиг
136	БТСГ	Тээвэр шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй.	Албан шаардлага	1	560.0	Хууль тогтоомж
137	БТСГ	Урсгал засварын зардлаар санхүүжүүлсэн "Спорт заалны засвар"-ын ажлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.	Албан шаардлага	1	41,615.3	Хууль тогтоомж
138	Боржигон мандал	Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ үзүүлж ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг дэмжих зорилгоор нэг удаа олгосон мөнгөн тэтгэмжийг ажилчдаас нярвын дансаар дамжуулан буцаан хураан авч, анхан шатны баримтгүй, тодорхой бус зардалд зарцуулсан.	Төлбөрийн акт	1	1,500.0	Хууль тогтоомж

139	Боржигон мандал	Эрүүл мэндийн төвийн дарга өөртөө тушаал гарган үр дүнгийн урамшуулал авсан.	Албан шаардлага	1	4,970.5	Төсвийн үр ашиг
140	ГХБХБГ	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор төсвийн хөрөнгөөр нэвтрүүлэг бэлтгэсэн, Завхан аймгийн ГХБХБГ-т туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж төсвийг хэмнэлтгүй зарцуулсан.	Албан шаардлага	1	5,439.4	Төсвийн үр ашиг
141	ГХБХБГ	Ажилчдад олгосон дархлаа дэмжих, халдвар хамгааллын хэрэгслийг тушаал шийдвэргүйгээр бэлтгэн, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн.	Албан шаардлага	1	2,327.8	Төсвийн үр ашиг
142	ГХБХБГ	Бараа үйлчилгээний бусад зардлыг ажилчдын эрүүл мэндийг дэмжих зардалд зарцуулсан.	Албан шаардлага	1	4,874.0	Зориулалт бус
143	ГХБХБГ	Эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг журамд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгосон	Төлбөрийн акт	1	217.7	Төсвийн үр ашиг
144	АЗДТГ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч нарт хүндэтгэл үзүүлэхдээ Аймгийн ИТХ-аас баталсан бэлэг дурсгалын зүйл гардуулах зардлын нормативаас илүү олгосон	Төлбөрийн акт	1	978.0	Төсвийн үр ашиг
145	АЗДТГ	Тайлант онд төсвийн хэмнэлтийн талаар авах хэмжээг зөрчин тавилга, эд хогшил худалдан авч, сургалт, семинар зохион байгуулсан	Албан шаардлага	1	14,672.2	Төсвийн үр ашиг
146	АЗДТГ	Зочид төлөөлөгчдөд өгөх бэлэг буюу бараа материалыг шууд зарлагаар хяналтгүй зарцуулсан	Албан шаардлага	1	14,091.2	Хууль тогтоомж
147	АЗДТГ	Албан хаагчдад дэмжлэг үзүүлэхдээ гэрээ хийгээгүй	Албан шаардлага	1	-	Төсвийн үр ашиг
148	АИТХ	Бичиг хэргийн ажилтны батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл цалин бодож олгосон.	Албан шаардлага	1	2,833.9	Төсвийн үр ашиг
149	Номын сан	Хөрөнгө зарцуулах шийдвэргүйгээр албан хаагчид нэмэгдэл цалин бодож олгосон.	Төлбөрийн акт	1	321.8	Хууль тогтоомж
150	Номын сан	Албан хаагчид цолны нэмэгдэл олгохдоо холбогдох журмаас өндөр хувиар бодож олгосон.	Төлбөрийн акт	1	321.8	Төсвийн үр ашиг
151	Техник хяналт	Аудитаар техник хяналтын сангаас үйл ажиллагаанд хамааралгүй 60,274,860.00 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бусад байгууллагад худалдан авсан.	Албан шаардлага	1	60,274.9	Хууль тогтоомж
152	СХАА	Төсвийн хөрөнгөөр тавилга, эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	3,036.0	Төсвийн үр ашиг
153	СДОА	Төсвийн хөрөнгөөр тавилга эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн	Албан шаардлага	1	836.0	Төсвийн үр ашиг
154	ТХДЖТ	Байгууллагын албан хэрэгцээнд сандал ширээ худалдан авч, хэмнэлтийн горим зөрчсөн.	Албан шаардлага	1	6,518.4	Төсвийн үр ашиг
155	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хуульд заасан "хөтөлбөр, арга хэмжээ"-ний шаардлагыг хангаагүй "Гамшгийн эрсдэлийг бууруулах нөөц бүрдүүлэх" арга хэмжээ, ажил үйлчилгээний урсгал зардлыг санхүүжүүлсэн.	Албан шаардлага	1	-	Хууль тогтоомж
156	ДЦ ЭЭС	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эрхлэгч, нягтлан бодогч	Албан шаардлага	1	3,495.9	Төсвийн үр ашиг

		нарын цалингийн нэмэгдлийг тогтоохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг үндэслэн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон.				
Нийт дүн				162	1,405,012.6	